

**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2015 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн
41 тоот тогтоолын
хавсралт**

Харилцаа холбооны зохицуулах хорооны
2015 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн
41 тоот тогтоолын
хавсралт

**ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ
ЖУРАМ**

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 7.4¹, Радио долгионы тухай хуулийн 11.4², Харилцаа холбооны тухай хуулийн 14.3³-т заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагад Харилцаа холбооны салбарт үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгохтой холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Хэрэв сонгон шалгаруулалтын баримт бичгийн зүйл, заалтууд нь уг журамтай зөрчилдсөн тохиолдолд энэхүү журмыг баримтална.

ХОЁР. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

- 2.1. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно.
Үүнд:
 - 2.1.1. Харилцаа холбооны зохицуулах хороо /цаашид Зохицуулах хороо гэх/ гэдэг нь Харилцаа холбооны тухай хуулийн 8-р зүйлийн 8.1 дэх хэсэгт заасан хороог;
 - 2.1.2. “Сонгон шалгаруулалт” гэдэг нь хамгийн сайн үнэлэгдсэн төслийг энэхүү журамд заасны дагуу шалгаруулах үйл ажиллагааг;
 - 2.1.3. "Сонгон шалгаруулалтын төсөл" /цаашид төсөл гэх/ гэдэг нь оролцогч нь Зохицуулах хорооны тогтоосон нөхцөл, шаардлагын дагуу боловсруулж, ирүүлсэн саналыг;
 - 2.1.4. "Сонгон шалгаруулалтын урилга" гэдэг нь Зохицуулах хорооноос сонгон шалгаруулалт явуулах тухай мэдэгдсэн, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарласан баримт бичгийг;
 - 2.1.5. “Оролцогч” гэдэг нь сонгон шалгаруулалтын урилгын дагуу төсөл ирүүлсэн иргэн, хуулийн этгээд болон хамтран ажиллах гэрээний үндсэн дээр нэг санал ирүүлсэн хэд хэдэн иргэн, хуулийн этгээдийг;

¹Эрх бүхий байгууллага шаардлагатай гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн дээр тусгай зөвшөөрөл олгож болно.

²Ижил радио давтамж ашиглах тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн сонирхогч этгээд өргөдөл гаргасан тохиолдолд өрсөлдүүлэн шалгаруулах журмаар тусгай зөвшөөрөл олгож болно.

³Нэг нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн этгээд өргөдөл гаргасан бол сонгон шалгаруулах замаар олгоно.

2.1.6. “Сонгон шалгаруулалтын баримт бичиг” гэдэг нь Зохицуулах хорооноос сонгон шалгаруулалтанд оролцогчдод зориулан гаргасан сонгон шалгаруулалтанд тавигдах шаардлагыг тодорхойлсон баримт бичгийг;

2.1.7. “Үнэлгээний ажлын хэсэг” гэдэг нь энэхүү журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулах зорилгоор Зохицуулах хорооны даргын тушаалаар байгуулсан ажлын хэсгийг;

2.1.8. “Ил тод байдал” гэж төрийн үйл ажиллагааны ил тод байдал болон иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангахтай холбогдуулж иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх, хараат бус байх, мэдээллээр хангах үйл ажиллагаа шуурхай байх зарчмын үндсэн дээр хуулийн⁴ 6-10 дугаар зүйлд заасан үйл ажиллагааг;

2.1.9. “Үйлчилгээ” гэж Харилцаа холбооны тухай хуулийн 3.1.4-т заасан үйл ажиллагааг

ГУРАВ. ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТААР ОЛГОХ НӨХЦӨЛ

3.1. Сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн төрөл, нийтийн үйлчилгээнд ашиглах радио давтамж, түүний ашиглалтын зориулалтыг Зохицуулах хорооноос дараах нөхцлийг харгалзан тогтооно. Үүнд:

3.1.1. Ижил радио давтамжийг ижил нутаг дэвсгэрт ашиглахаар хэд хэдэн хуулийн этгээд хүсэлт гаргасан бол;

3.1.2. Нэг нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авахаар хэд хэдэн этгээд өргөдөл гаргасан бол;

3.1.3. Эрхбүхий байгууллагаас зах зээлийн зохицуулалт хийх бодлого, зохицуулалтын шийдвэр гарсан бол

3.2. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах тухай шийдвэрийг Зохицуулах хорооны хуралдаанаар тогтооно.

ДӨРӨВ. СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ

4.1 Зохицуулах хорооны эрх, үүрэг

4.1.1 Сонгон шалгаруулалтын эцсийн шийдвэрийг Зохицуулах хорооны хуралдаанаас гаргана.

4.1.2 Сонгон шалгаруулалтаар олгох тусгай зөвшөөрлийн эрхийн төлбөрийн хэмжээг Зохицуулах хорооны хуралдаанаар тогтооно.

4.1.3 Зохицуулах хороо нь үнэлгээний ажлын хэсгийн үйл ажиллагаа, үнэлгээний дүгнэлт нь энэхүү журам, холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгуулах эрхтэй.

4.1.4 Зохицуулах хороо үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг дараах тохиолдолд зөрчилтэй гэж үзнэ. Үүнд:

4.1.4.1 Үнэлгээний ажлын хэсэг дүгнэлт гаргахдаа энэхүү журамд заасан үйл ажиллагааны дараалал, хугацааг баримтлаагүй;

- 4.1.4.2 Үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт нь сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан нөхцөл, шаардлагад нийцээгүй;
- 4.1.4.3 Үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлт нь хууль тогтоомж болон энэхүү журамд заасан бусад нөхцөлд нийцээгүй

4.2 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг

- 4.2.1 Үнэлгээний ажлын хэсэг нь сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх ба байнгын бус ажиллагаатай байна.
- 4.2.2 Үнэлгээний ажлын хэсэг нь дор дурдсан чиг үүрэгтэй байна. Үүнд:
 - 4.2.2.1 Сонгон шалгаруулалтын урилга, сонгон шалгаруулалтын баримт бичгийг боловсруулах
 - 4.2.2.2 Сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авах, сонгон шалгаруулалтын төслийг нээх
 - 4.2.2.3 Сонгон шалгаруулалтын төслийг хянан үзэх, үнэлэх, үнэлгээний дүгнэлт гаргаж Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулах
- 4.2.3 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан нь сонгон шалгаруулалтанд оролцогчтой сонирхлын зөрчилтэй бол энэ тухай үнэлгээний ажлын хэсгийн ахлагчид мэдэгдэж, үнэлгээний ажлын хэсгийн гишүүнээс өөрийн саналаар татгалзах үүрэгтэй.
- 4.2.4 Үнэлгээний ажлын хэсэгт гишүүнээр ажиллахад ашиг сонирхлын зөрчил үүссэн учир гишүүн өөрөө татгалзсан тохиолдолд Хорооны дарга ажлын хэсгийн гишүүн эсвэл зарим гишүүдийг өөрчилж, чөлөөлж нөхөн томилно.
- 4.2.5 Сонгон шалгаруулалтын ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон албан тушаалтан нь сонгон шалгаруулалтын талаарх мэдээллийн нууцыг хадгалах талаар баталгааг бичгээр гаргана.
- 4.2.6 Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд ил тод байдлыг хангах нь зайлшгүй гэж үзсэн Хорооны гишүүний хүсэлтийг үндэслэн 2-оос дээшгүй тооны хорооны гишүүнийг сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оролцуулж болно.
- 4.2.7 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн шийдвэр нь /цаашид “үнэлгээний дүгнэлт” гэх/ хурлын тэмдэглэл хэлбэртэй байна.
- 4.2.8 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын төсөл нээснээс хойш ажлын 30 хоногт багтаан сонгон шалгаруулалтын үнэлгээг хийж дуусгана.
- 4.2.9 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн гишүүд нь оролцогчоос ирүүлсэн мэдээллийн үнэн бодит эсэхийг магадлах зорилгоор холбогдох эрх бүхий байгууллагад хандах эрхтэй.
- 4.2.10 Сонгон шалгаруулалтын үнэлгээний дүгнэлтэд үнэлгээний ажлын хэсгийн бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд эсрэг саналтай байсан гишүүн үнэлгээний дүгнэлтэд энэ тухайгаа тэмдэглүүлж гарын үсгээ зурна.

4.3 Сонгон шалгаруулалтын баримт бичиг боловсруулах, сонгон шалгаруулалтын урилгыг нийтэд зарлан мэдээлэх

- 4.3.1 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичгийг бэлтгэж, Зохицуулах хорооны хуралдаанд танилцуулж баталгаажуулна.
- 4.3.2 Сонгон шалгаруулалтын баримт бичигт сонгон шалгаруулалтанд оролцогч зохих шаардлага хангасан сонгон шалгаруулалтын төсөл бэлтгэж ирүүлэхэд шаардлагатай бүх мэдээлэл, сонгон шалгаруулалтад оролцогчдод тавих шаардлага, тэдэнд өгөх заавар, сонгон шалгаруулалтын төслийг үнэлэх аргачлал, хамгийн сайн үнэлэгдсэн төслийг шалгаруулах аргачлал, Зохицуулах хорооны санал болгож байгаа гэрээний нөхцлүүд, техникийн тодорхойлолт, зураг, сонгон шалгаруулалтын жишиг маягтуудыг тусгана.
- 4.3.3 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичиг бэлтгэхдээ тухайн сонгон шалгаруулалтанд оролцох сонирхолтой этгээдээс өрсөлдөөнийг хязгаарлахад хүргэж болох зөвлөгөө авахыг хориглоно.
- 4.3.4 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичгийг Зохицуулах хорооны хуралдаанаар баталгаажуулсны дараа сонгон шалгаруулалтын урилгыг сонгон шалгаруулалтын төсөл хүлээж авах эцсийн хугацаанаас 30-аас доошгүй хоногийн өмнө үндэсний хэмжээний өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон Зохицуулах хорооны цахим хуудсаар нийтэд зарлана.
- 4.3.5 Сонгон шалгаруулалтын урилгад дараах мэдээллийг тусгана. Үүнд:
 - 4.3.5.1 Сонгон шалгаруулалтаар эрхлэх үйлчилгээний нэр;
 - 4.3.5.2 Сонгон шалгаруулалтаар олгох радио давтамжийн зурвас ашиглах эрхийн тоо;
 - 4.3.5.3 Сонгон шалгаруулалтын баримт бичиг, бусад мэдээлэл авах, сонгон шалгаруулалтын төсөл ирүүлэх хаяг;
 - 4.3.5.4 Сонгон шалгаруулалтын баримт бичгийн үнэ;
 - 4.3.5.5 Сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авах эцсийн хугацаа

4.4 Сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацаа

- 4.4.1 Сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацаа нь сонгон шалгаруулалтын төсөл нээсэн өдрөөс хойш сонгон шалгаруулалт зохион байгуулах ажлын 30 хоног, хамгийн сайн гэж үнэлэгдсэн төсөл ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулах ажлын 15 хоног, нийт ажлын 45 хоног байна.
- 4.4.2 Зохицуулах хорооны хуралдаанаас шаардлагатай тохиолдолд сонгон шалгаруулалт хүчинтэй байх хугацааг нэг удаа ажлын 30 хоног хүртэлх хугацаагаар сунгаж болно.

4.5 Сонгон шалгаруулалтын баримт бичиг, түүнтэй холбоотой мэдээллийг олгох

- 4.5.1 Сонгон шалгаруулалтын баримт бичгийг бэлтгэх, хэвлэн олшруулах түгээх буюу сонгон шалгаруулалтыг зохион байгуулах өртгөөр үнэлж, сонгон шалгаруулалтанд оролцохыг сонирхогчдод тухайн тогтоосон үнээр саадгүй олгоно.
- 4.5.2 Сонгон шалгаруулалтанд оролцохыг сонирхогч нь сонгон шалгаруулалтын баримт бичигтэй холбоотой тодруулга, нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын 5 -аас доошгүй хоногийн өмнөсонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэгт зөвхөн албан бичгээр гаргаж болно.
- 4.5.3 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь энэ журмын 4.5.2-т заасан хүсэлтэнд өгөх хариу тодруулгыг сонгон шалгаруулалтын баримт бичиг худалдан авсан бүх этгээдэд нэгэн зэрэг бичгээр илгээх бөгөөд уг бичгийг шуудангийн байгууллагад хүлээлгэн өгснөөр хариу тодруулга, нэмэлт мэдээллийг хүргүүлсэнд тооцно.

4.6 Сонгон шалгаруулалтын төслийг хүлээн авах, нээх

- 4.6.1 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцогчдод төсөл бэлтгэж ирүүлэх ижил хугацаа олгоно.
- 4.6.2 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь төсөл хүлээн авах эцсийн хугацааг сонгон шалгаруулалтыг анх зарлан мэдээлсэн өдрөөс эхлэн тооцно.
- 4.6.3 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтад оролцохоор холбогдох баримт бичигт заасан хугацаанд, дурдсан хаягаар, заасан хэлбэрээр ирүүлсэн сонгон шалгаруулалтын төслийг хүлээн авч, тэмдэглэл үйлдсэнээр хүлээн авах ажиллагааг дуусгавар болгоно.
- 4.6.4 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын төсөл хүлээн авах эцсийн хугацаанаас хожимдож ирсэн, эсхүл сонгон шалгаруулалтын баримт бичигт зааснаас өөр хэлбэрээр ирүүлсэн сонгон шалгаруулалтын төслийг хүлээж авахгүй бөгөөд нээлгүйгээр буцаана.
- 4.6.5 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь энэхүү журмын 4.6.3-д заасны дагуу хүлээн авсан бүх сонгон шалгаруулалтын төслийг заасан газар, товлосон хугацаанд сонгон шалгаруулалтанд оролцогчдыг байлцуулан нээх бөгөөд сонгон шалгаруулалтын төслийг нээх хугацааг сонгон шалгаруулалт хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор байхаар товлоно.
- 4.6.6 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын төслийг нээхдээ тэмдэглэл үйлдэх ба оролцогчийн төлөөлөл гарын үсэг зурна.
- 4.6.7 Төслийг нээх үед энэхүү журмын 4.6.5–4.6.6-дзааснаас бусад үйл ажиллагаа явуулах, шийдвэр гаргахыг хориглоно.

4.7 Сонгон шалгаруулалтын төслийг үнэлэх, дүгнэлт гаргах

Үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтанд оролцогчдын зүгээс холбогдох шаардлагын дагуу ирүүлж, хүлээн авсан төсөл бүрийг сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан аргачлалын дагуу үнэлж, тэдгээрээс хамгийн сайн гэж үнэлэгдсэн төслийг аргачлалын дагуу шалгаруулж дүгнэлт гаргана.

4.8 Бүх төслөөс татгалзах

4.8.1 Оролцогчдоос ирүүлсэн бүх төслүүд сонгон шалгаруулалтын баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд үнэлгээний ажлын хэсэг нь бүх төслөөс татгалзана. Энэ тухай үнэлгээний дүгнэлтэд тусгана.

4.8.2 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг бүх төслөөс татгалзсан шийдвэр гаргасан тохиолдолд Зохицуулах хорооны хуралдааны шийдвэрээр сонгон шалгаруулалтыг дахин зарлаж болно.

4.9 Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааг тайлагнах, шийдвэр гаргах

4.9.1 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсгийн ахлагч нь үнэлгээ дууссан тухай мэдээллийг үнэлгээний дүгнэлт гарснаас хойш ажлын 1 хоногийн дотор Зохицуулах хорооны хуралдааны нарийн бичгийн даргад мэдэгдэнэ.

4.9.2 Сонгон шалгаруулалтын үнэлгээний ажлын хэсэг нь сонгон шалгаруулалтын баримт бичгийн шаардлагыг хэрэгжүүлэх чадварыг хангасан саналуудыг хамгийн өндөр үнэлгээ авсан байдлаар нь жагсааж, үнэлгээний дүгнэлтийг Зохицуулах хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр танилцуулна.

4.9.3 Зохицуулах хорооны гишүүд нь шийдвэр гаргах зорилгоор үнэлгээний ажлын хэсгийн гишүүн тус бүрийн үнэлгээнээс бусад мэдээлэлтэй танилцаж болно.

4.10 Сонгон шалгаруулалтын шийдвэрийг мэдээлэх

4.10.1 Үнэлгээний ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын талаар Хорооны хуралдааны шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 1 хоногийн дотор сонгон шалгаруулалтанд ялагчийн талаархи мэдэгдлийг бэлтгэн хуралдааны нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

4.10.2 Зохицуулах хорооны хуралдааны нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтанд ялагчийн талаарх Хорооны хуралдааны шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор 4.10.1-д заасан мэдэгдлийг зохицуулах хорооны хуралдааны тогтоолын батламжлалын хамт сонгон шалгаруулалтанд ялагчид хүргүүлнэ.

4.10.3 Үнэлгээний ажлын хэсгийн нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын талаар Хорооны хуралдааны шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор сонгон шалгаруулалтанд шалгараагүй тухай мэдээллийг шалгараагүй

оролцогчдод албан бичгээр хүргүүлнэ.

4.11 Гэрээ байгуулах

- 4.11.1 Зохицуулах хорооны хуралдаанаар сонгон шалгаруулалтын ялагчтай гэрээ байгуулах эрхийг Зохицуулах хорооны даргад олгоно.
- 4.11.2 Зохицуулах хорооны дарга нь 4.10.2 болон 4.10.3-т заасан мэдэгдлийг сонгон шалгаруулалтанд оролцогчдод хүргүүлснээс хойш ажлын 5-аас доошгүй хоногийн дараа энэхүү гэрээг байгуулна.
- 4.11.3 Сонгон шалгаруулалтанд шалгарсан оролцогчид 4.10.2-т заасан мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 10 хоногийн дотор сонгон шалгаруулалтын эрхийн төлбөрийг төлж, гэрээ байгуулахаар Зохицуулах хороонд хандана.
- 4.11.4 Сонгон шалгаруулалтанд шалгарсан оролцогч нь гэрээ байгуулахаас татгалзсан эсвэл энэхүү журмын 4.11.2-4.11.3-т заасан хугацаанд гэрээ байгуулаагүй бол Зохицуулах хорооны дарга нь удаах “хамгийн сайн” үнэлэгдсэн төсөл ирүүлсэн оролцогчтой гэрээ байгуулах ба ингэхдээ энэхүү журмын 4.11.2 болон 4.11.3 -т заасан хугацааг баримтална.

ТАВ.МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

- 5.2 Оролцогч нь сонгон шалгаруулалттай холбоотой Зохицуулах хорооноос гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолдшүүхэд гомдол гаргахэрхтэй.

ЗУРГАА.ХАРИУЦЛАГА

- 6.2 Үнэлгээний ажлын хэсгийн гишүүн нь холбогдох хууль болон энэхүү журмыг зөрчсөн нь тогтоогдвол түүнд холбогдох хууль, Зохицуулах хорооны хөдөлмөрийн дотоод журам болон ёс зүйн дүрмийн дагуу Зохицуулах хорооны дарга хариуцлага ногдуулна.
- 6.3 Үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтээс эсрэг саналтай ажлын хэсгийн гишүүн тэмдэглэлд саналаа тэмдэглүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болно.

----- о О о -----